



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/103

Алтрага

**Хүлээж авах хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Багт монгол гэртэй болох” ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Пүрэв-Очир
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүн: Д.Баярхүү
(Тамгын газрын нярав)
Нарийн бичгийн дарга: Г.Батнасан
(Хөдөлмөр халамж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Багт монгол гэртэй болох” ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ОДСЭР



Document-Zahiramg

6729010237